

НИЙТЛЭЛ, ШҮҮМЖ, НОМ ЗҮЙН ТАНИЛЦУУЛГА

Оуэн Латтимор

МАЛЧИД, ТАРИАЧИД, ХОТ СУУРИНЫ СОЁЛ*

Хятадын Цагаан хэрмийн гадна орших нүүдэлчдийн дунд амьдарч явсан над монголчуудын нүүдэл, хятадын суурьшил хоёрын эрс ялгаа ил тодхон харагддаг байв. Гэлээ ч Азийн нүүдэлчдийг хятадын Хэрмийн хажуугаас харсанд орвол түүнийг Ойрхи Дорнод буюу Төв Азийнхантай жишин үзэх нь илүү дээр юм гэсэн санаа над сүүлийн үед төрдөг боллоо. Үүнд Зөвлөлт, Монголын археологчдын нээлт, ялангуяа саяхан хүртэл хятадын түүхийн бөөн дунд хэт бүрхэгдэж нөгөөтээгүүр хятад түүхчдийн тэрхүү өнө эртнээс хуримтлуулсан баримт сэлтийг бусад орны эрдэмтэд ямар ч шүүмжлэлгүй авч хэрэглэдэг байсан, тийм улс орныхоо түүхийг эдүгээ дахин шинээр нээж байгаа БНМАУ-ын эрдэмтдийн туурвисан бүтээлүүд намайг тийм шинэ дүгнэлтэд хүргэж байна.

Холбоот байр зүй:**Харилцан нөлөө, Ахиц хөгжил**

Хятад нь хот суурингаар хүрээлэгдсэн тариалангийн талбай ихтэй бөгөөд хот хоорондын худалдаа тэрхүү газар тариалан эрхлэдэг районуудыг дамжин явагддаг байснаас биш нүүдэлчдийн нутаг районоор дайрах нь ховор байжээ. Гэтэл Ойрхи Дорнод болон Төв Азид газар тариаланг Хятадтай адил газар сайгүй биш, зөвхөн томоохон гол мөрний сав, зарим баян бүрдийг дагаж эрхлэх учир хот хоорондын худалдааны зам нүүдэлчид нутагладаг говь тал, уулархаг районыг заавал дайрч өнгөрдөг байжээ. Үүнтэй холбогдон Ойрхи Дорнод, Төв Азийн хотуудын худалдаа нь хятадын худалдаанаас хамрах хүрээ болон арилжих эд барааны хувьд ч ялгаатай байжээ. Нүүдэлчид нь зөвхөн явуулын худалдаачид буюу жинчдэд мал худалддаг төдийгүй харин өөрсдөө жинчин худалдаачид болох явдал ч цөөнгүй байжээ. Ингэж нааш цааш явж хутгалдсанаас нүүдэлчид ба суурьшмал иргэд харилцан бие биенээ ойлголцох байдал тогтдог бөгөөд харин ийм харилцаа Хятад ба их хэрмийн гаднах «бүдүүлэгчүүд»-ийн хооронд байгаагүй юм. Нэрд гарсан Торгон замаар ч гэсэн хятад худалдаачид Газрын дундад тэнгис хүрч байсан нь үгүй. Харин гадаадын худалдаачид л хятадын хил хязгаарт ирж худалдаа хийгээд хятадаас эд бараа авч буцдаг байжээ. Хан, Тан улсын үед Хятад нь Синьцзяныг хяналтандаа авч (харин колоничлосонгүй) байсан учир явуулдаг гол бодлого нь эдийн засаг биш юуны өмнө стратегийн шинжтэй байжээ. Ийм учраас тэр үеэс хадгалагдаж ирсэн хятадын түүхийн мэдээ сэлт нь эх үүсвэр, шинж чанарын хувьд гол төлөв цэрэг, дипломат болон албаны бусад хэрэгт хамаарна. Мөн шашны холбогдолтой зарим мэдээ нь түүхэнд хамаарах бөгөөд харин сайтар судлууштай зүйл юм. Хятадууд нь бүддийн шашныг Синьцзянаас олж (тэд хожим марксизмыг хилийн чанадаас олсонтой адил) нутагтаа авчирчээ. Хятад

* Pastoral Productions and Society. Maison des Sciences de L' Homme and Cambridge University Press. 1979-д хэвлэгдсэн эхээс бага зэрэг товчлон оруулав.

нь бурхан номногчдын хүчээр бүддийн шашинд орсонгүй. Тэд харин ном судар орчуулах, энэтхэг, цейлонд лам хувраг явуулж сургах буюу ном судар цуглуулах ажлыг санаачилж байжээ. Бүддийн шашныг хятадууд сүм хийдэд нь татваргүй чанар эдлүүлэх нарийн аргаар дэмжсэн юм. Энэ газар нь сүм хийдийн эдийн засгийн үндэс болж байжээ.

Гэтэл Ойрхи Дорнод ба Төв Азийн шашны сүм хийдүүд бас газартай байсан боловч тэр нь сүм хийдийн онцлох шинж чанар биш байв. Юуны өмнө энд зороастризм, буддизм, мапихеизм, несториан, христос бас ислам зэрэг олон шашин хутгалдаж байв. Цаашилбал Сири-гээс Хятад, Энэхтэг хүртэл шашин, хэл, худалдаа цөм гинжин холбоотой байжээ. Хэл, шүтлэг нэгтэй худалдаачид нь өөр хэл, шашинтай хотод очих дээрээ буудаг буудал, бараа агуулах, мөргөдөг дуган сүм зэрэгтэй байжээ. Эдгээр ялгаа нь янз бүрийн хүмүүс үзэл суртлын хувьд янз бүр, ертөнцийг үзэх үзэл өөр өөртэй болгож байв. Зөвхөн монголчуудын хувьд л гэхэд хятадууд их төлөв захирч тушаах хүнд сурталт ёсны үүднээс ханддаг байхад Рашид-ад-Дин голлож худалдааны талаас нь үздэг байжээ.

Сөргөлдөөнт байр зүй: Уршиг, Ухралт

Хятадын Цагаан хэрэм бол газар зүй, цаг уур, хөрс ургамлын байгалиас заяасан хил дээр хүний гараар нэмж барьсан зүйл юм. Хэрэм нь тал нутаг тийш тэлж байсан Умард Хятадын тархай бутархай ванлигуудын уеэс хэсэг бусгаар баригджээ. Тэдгээр ванлигууд өргөжих тусам одоо Хятадад «бүдүүлгүүд» гэж нэрлэж байгаа овог аймаг ястангуудыг зарим талаар түрж хөөх буюу дотогш хумьж авлаа. Тэдгээр омог ястангууд нь «ердийн» Хятадаас хэл яриа зэргийн хувьд аль зэрэг ялгаатайг мэдэхэд хэцүү билээ. Зарим нь «хоцрогдсон» хятадууд байж мэдэх юм. Гэхдээ тэд «жинхэнэ» хятадуудыг бодвол арга ажиллагаа нь бүдүүлэг боловч хэмжээний хувьд давуу их газар тариалан, мал аж ахуй эрхлэж байжээ. Гуравдугаар зууны үед Чин (үүнээс Чайна буюу хятад гэдэг нэр гарчээ) улс бусад ванлигуудаа байлдан дагуулж Хятадын анхны эзэнт улсыг байгуулжээ. Чин улс цаашдаа урьдах ванлигуудын барьсан хэсэг хэсэг хануудыг залгаж нэгтгэн их хэрэм хил болгожээ. (Хятадын их хэрмийг монгол түүх сударт хятадын Цагаан хэрэм, бүр тодорхойгоор түмэн газрын цагаан хэрэм гэдэг-орч.). Энэ хил бол хятадын эзэнт улсын дэвсгэр нутгийн зохих өргөтгөлийг сайн дураар заагласан шугам хязгаар гэдгийг энд тодруулах нь чухал юм. Өөрөөр хэлбэл Цагаан хэрэм нь Хятадын эсрэг нүүдэлчдийн түрэмгийллийн улмаас байгуулсан зүйл биш юм. Тийм түрэмгийлэл нь харин хилийн шугам тогтоосноос хойш, ялангуяа нүүдэлчид ба хятадын хоорондох худалдааны тэгшгүй байдлаас шалтгаалан үүсдэг болжээ. Нүүдэлчид нь мал, ноос, үс, арьс шир зэрэг түүхий эд өгч хятадаас үр тариа, нэхмэл, төмөр эдлэл авдаг боловч өгч авалцах үнэ өртөг харилцан тэгш биш байжээ. Энэ байдал нь урьд тусгай ванлигууд хэсэг бүлэг омог аймагтай худалдаа хийж байсан үеийг бодвол хятадын нэгдсэн эзэнт улс байгуулагдаж мөн түүний зэрэгцээгээр хүннү нарын омог аймгуудын холбооноос бүрдсэн нүүдэлчдийн эзэнт улс буй болоход улам ч даамжирчээ. Харилцан тэгш журмын худалдаагүй ийм хоёр улс байгуулагдахад нөлөөлсөн эдийн засгийн зарим шалтгаан байжээ.

Хятадууд тосгоны хог шавхруугаар голдуу тэжээсэн гахайн мах хэрэглэх учир хонь, үхрийн махны хэрэгцээ нь их хязгаартай байжээ. Хувцасны хувьд гэвэл хятад хүн эхний үед олс таар, сүүл үед хөвөн, баячуул нь торго хэрэглэж ноосоор хувцас хийх нь ховор байжээ. Нөгөө талаар хятадууд гадагш гаргаж байгаа бараагаа хятад орны баялгийг

хоослох зүйл гэж үздэг байв. Ийм учраас худалдаа нь эдийн засгийн шаардлагаар биш улс төрийн бодлогоор зохицуулагддаг бөгөөд тэгэхдээ хягадууд нүүдэлчин аймгуудыг хооронд нь уралцуулах зорилгоор заримыг нь боож хавчиж, заримыг урамшуулах жишээтэй ханддаг байжээ. (Ойрхи дорнод ба Төв Азид үүнээс эрс өөр байдалтай юм. Энд хот сууринд мах, ноос аль аль нь хэрэгтэй учир худалдаа нь бие биеийн хэрэгцээг хангах харилцан тэгш байдалтай ажээ).

2000 жилийн тэртээ байгуулагдсан Хятад улс газар тариаланг онцлон эрхлэж хүний олондоо дулдуйдаж ажлын мал ч ховор хэрэглэдэг байжээ. Тэдэнд ферм ч байсангүй, тосгоноос шууд алхаж талбай дээрээ ирж ажиллаад буцдаг ба том жижиг тосгонууд нь хотоо тойрч нэг буюу хоёр өөрийн газраас холгүй зайд оршино. Хотууд нь хамгаалалтын хана хэрэмтэй бөгөөд засаг захиргааны төв болж байв. Хятадын Цагаан хэрмээс хойш ус ховор учир хагалаагүй газар их байдаг нь бас хот тосгодоос алслагдсан байдаг юм. Энэ нутагт тариа тариалаа ч гэсэн он жилээр суурьшиж тосгон болсон их хэрмийн дотор орших «жинхэнэ хятад» маягийн тариачдыг бодвол хараахан «хятад бус» тариачид байжээ. Хятадын анхны улсуудын үед зарим ард түмэн (Цагаан хэрмийг барихад буюу барихаас өмнө) дотогш хумигдан хоцорсон нь Хятадын эртний бичиг сударт харь гаралтай нэр овгийн дор тэмдэглэгдэн үлдсэн ба зарим хэсэг нь гадагш түрэгдэж тэр үед баригдаагүй байсан Цагаан хэрмээс хойшхи тал нутгийн тийш одсон ажээ. Харин тийм ард түмэн нь нүүдэлчин хүн амын чухал бүрэлдэхүүн хэсэг болж тухайн үедээ хятадад хөгжиж байснаас дутуугүй нарийн мэргэжлийн газар тариаланг нүүдэлчдийн нутагт үүсгэн хөгжүүлж байжээ. Бид энэ байдлыг археологийн нээлт хөгжих тусам улам тодорхой мэдэх болно. Бидний одоогийн мэдлэгийн хир хэмжээнд бол нүүдэлчдийн нийгмийн хувьсгал өөрчлөлтийг судлахдаа «нутаг хорих», «нутаг тавих» буюу «цагдах» гэх мэт үгээр илэрхийлэгдсэн нэр томъёог их болгоомжтой тайлбарлах ёстой. Энэ бол тушаал шийдвэр буюу санаа зоригийн хүчийг байгаль орчинтой холбогдуулан хэрэглэж байсан газар зүйн материалистуудын үгсийн сан юм. Энд бид зөвхөн өвлөж уламжласан нэг замаа дагадаг адгуус амьтад, нүүдлийн шувуудтай адилгүй ямар ч хүн, тэгэх гусмаа бүр балар эртний хүн ч гэсэн зохих шийдвэр гаргаж дагаж шийтгэх чадалтай байсан баримтыг анхаарах хэрэгтэй билээ.

Бид өнөөгийн байдлыг аваад үзье. Цагаан хэрмээс хойш, Өвөр Монголын тал нутагт урт зурвас сайхан билчээр бий. Ургасан өвс нь хөрсөн дэх үндсэндээ чийгээ хадгалж тэр чийг нь ямар ч тарианы ургацыг гандааж чадах удаан хугацааны ган гачгийг даадаг ажээ. Энд мал, тариалан аль алины нь мэдлэгийн эхэн шатны үед ч атугай балар цагийн хүмүүс ч гэсэн ямар ч шахалтгүйгээр сонголтоо өөрөө хийж мал аж ахуйгаар мэргэжихийг хүсчээ. Ядуу тариачинд орвол чинээлэг малчин байсан нь ч дээр билээ. Ийм зүйл Хан улсын түүх сударт ч дайралддаг юм. Бүр тэр үед Өвөр Монголын баруун хэсгийг эзэмшиж газар хагалах санал гарчээ. Тийнхүү эзлэн суурьшигчид нь цэрэг байх ёстой байжээ. Тэд хил хязгаарыг сахин хамгаалахын хамт тариа тарьж өөрсдийгөө тэжээх ёстой юмсанжээ. Гэтэл энэ төлөвлөгөөг эсэргүүцэж нэг сайд эзэн хаандаа айлтгажээ. Юу гэвэл тэр нутаг бол газар тариаланд маш тохиромжгүй, тийм учраас тариачин цэргүүд ч нүүдэлчдийн аж амьдрал дээрийг мэдээд бүдүүлэгчүүд рүү зугтааж орхивол яана гэжээ. Энэ бол «бүдүүлэгчүүдийн» амьдрал соёлч хятадынхаас тодорхой нөхцөлд дээр болохыг хятадын уламжлалт маягаар бүдүүвчилдэг он дарааллын бичигт оруулсан ховор баримтын нэг юм.

Ийм учраас Умард Хятадын балар эртний хүн амын зарим хэсэг нь тариалангаар мэргэжиж, хот сууринд идээшиж, соёлжсон, хятадын жин-

хэнэ суугуул хятадуудад хөөгдөн тал нутаг тийш ухарсан ба зарим хэсэг нь олигтой амь зуулга хайж чөлөөтэй явахын эрхээр төлөв өөрсдийн сайн дурын үндсэн дээр тал нутаг бараадсан гэдэг дүгнэлт хийж болмоор санагдана. Харин энэ хоёр үйл явц нэгэн зэрэг явагдсан байж таарна. (Энд би Монголын ард түмэн цөм хятадаас ирсэн гэж байгаа хэрэг биш нь мэдээж. Бүр газар тариалан билчээрийн мал аж ахуй аль аль нь ор сураггүй байсан үед монголд нэн балар цагийн хүмүүс нутаглаж байсан ба хожим зарим нь Сибирийн ой тайга болон Төв Азийн баян бүрдүүдээс орж иржээ).

Хятадын их хэрмийн түүхтэй холбогдох томоохон үйл явдлын нэг бол дайн дажин бөгөөд энэ талаар эрх биш товч боловч өгүүлэх нь зүйтэй билээ. Бүдүүлэгчүүдийн тухай бидний анх олж дуулсан зүйлүүд цөм тэднээс аль эрт бичиг үсэгтэй болсон соёлт ард түмний бичиг судрыг дамжин ирсэн ба тэдгээр соёлжсон улс нь бүдүүлэг аймгийг ажиллаж хөдөлмөрлөх, төлөв түвшин амьдрахын оронд алж талахыг урьтал болгодог гэж ном судартаа дүрслэсэн байдаг билээ. Энэ бол маш субъектив үнэлэлт болохыг бид Төв ба Дундад Азийн хот тосгон, нүүдэлчдийн хоорондох худалдааг бодвол хятадын Их хэрэм хавийн худалдаа илүү тэнцвэргүй байсан тухай дээр дурдсан зүйлээс нэгэнт ухааж мэдсэн билээ. МЭӨ III зууны үед хятадын нэгдсэн эзэнт улс буй болсны дараахан агуу их овог аймгийн холбоо буюу Хүннүгийн эзэнт улс байгуулагджээ. Энэ тохиолдлыг эдийн засгийн үүднээс ч тайлбарлаж болно. Бүр их хэрмийг баригдаагүй байх үед тэр хавьд оршиж байсан аль ч хятад ванлиг нь хятадын бусад ванлигийн хотууд, ялангуяа нийслэл хоттой наймаа хийх сонирхол илүү ихтэй байжээ. Тэрээр алс зайдуу орших нүүдэлчдийн түүхий эд бүтээгдэхүүнийг төдий л их хэрэглэдэггүй байжээ. Гэтэл нүүдэлчин малчдын түүхий эд бүтээгдэхүүн нэмэгдэж мал аж ахуй нь өсөх тусам малчдын хэрэгцээнээс нь илүү бүтээгдэхүүн үүсдэг байна. Зарим өрх нөгөөхөө бодвол хөрөнгө чинээлэг болох жишээтэй бөгөөд хөрөнгө нь мэдээж хэрэг өвлөгдөх тавилантай байдаг болохоор яван явсаар овог аймгийн дотор язгууртан баячуул үүсч гарах болжээ. Мал сүрэг, ноос үс зэрэг нүүдэлчин аймгийн язгууртны эдлэн хөрөнгө буюу нэг үгээр тэр өрхийн хэрэгцээний илүүдэл бүтээгдэхүүнд хятадууд төдий л дургүй бөгөөд харин тэдний торго мэт нандин чамин бараанд бүдүүлэгчүүд унадаг байжээ. Нэг талаар нүүдэлчдийн удирдагчид нь ганц торго ч биш бусад нэхмэл бөс даавуу, үр тариа зэрэг зөвхөн өөртөө биш өөрийнхөө овог аймгийнханд хүртээх эд бараа шаардаж бөөн бөөнөөр санаа нэгдэж босон хил хязгаарт нь занал учруулж байгаад тэнцвэргүй үнээр ч худалдахаа татгалзсан зүйлийг нь улс төрийн буулт хийлгэж хүчээр авах ч явдал байдаг байжээ.

Хятад нэгдсэн эзэнт улс болж хуучин хэсэг бусаг байсан их хэрмийг нийлүүлснээс хойш ганц нэг овог аймаг тийнхүү сүр далайлгах аргагүй болжээ. Тийнхүү хил хавийн бүлэг тасаг аймгууд бүгдээрээ хамтарч нэгдмэл Хятадын өөдөөс нэгдмэл хүчээр тэмцэх чадвартай болтлоо ойр хоорондоо өрсөлдөн тэмцэлдэж байсныг Хятадын хаадын түүх сударт бүдүүлгүүд эрх дархаа булаалдан хийж байсан үргэлжийн дайн дажин гэж тоочсон байдаг нь тийм учиртай билээ. Гэтэл үүнээс хойш дараагийн шатанд хятадууд баруун замын баян бүрдүүдийг дайруулан торгон замыг нээж капиталист эдийн засгийн бус замаар Монголын нүүдэлчдийг шахан зайлуулжээ. Үүний гол шалтгаан бол Хятадын илүүдэл торгонд гадаадын зах зээл шаардагдаж байсан нь илэрхий боловч нөгөө талаар алс баруун талын нүүдэлчдийг Хятадын худалдаанд сонирхолтой болгож улмаар түүнээс олох ашиг хонжоогоо бодож хятадын хөрш зэргэлдээ мон-

голчуудад дайсагнуулах зорилгод чиглэгдэж байжээ. Эдийн засаг-улс төр-цэргийн ийм бүтэц байгуулалт нэгэнт буй болж ирэхэд түүх шатаа сэлгэж шинэ шатанд шилжжээ. Ийм үе шат нь эргэж давтагдах учиртай гэдэг Хятадын уламжлалт үзлийг өрнөдийн түүхчид тэр аяар нь авч хэрэглэсэн түүхтэй. Цэрэг зэвсгийн хүчээр байгуулагдсан эзэнт улс эхэн үедээ хүчтэй боловч аажмаар сулран суларсаар эцсийн бүлэгт өргөн олны гүн эсэргүүцэл дунд мөхнө. Дараа нь мөн үйл явц дахин давтагдана. Энэ нь эзэнт төрөө байгуулсан хятадууд, их хэрмийн гадна талаас бүдүүлгүүдийн байгуулсан Умар Хятад дахь тархай бутархай ванлигууд болон эзэнт улсууд хийгээд нийт байлдан дагуулагчид (Монголын эзэнт улс, Манжийн хаант улс) цөмий нь хувь заяаны тавилан болсон гэж үздэг билээ. Бүдүүлэгчүүдийн байгуулсан ванлиг болон эзэнт улсуудын хувьд бас өөр нэг баримтлал нэмэгдсэн юм. Энэ нь бүдүүлгүүд цөм Хятадад залгигдан шингэж хятадтай ижил хятад болсон гэдэг тухай юм. Хэлний ялгааг амархан арчдаг сонин бичгийн нөлөө, нөгөө талаар хятад хэлээс үндсээрээ ялгаатай турк-монгол-түнгүс хэлний группээс хятадын Их хэрмээр зааглагддаг зэрэг нь дээрх баримтлалыг бататгаж байна. Хэл зүй, үгийн дэс дараа, авиа зүйн ялгаа нь маш их учир аль аль тал руугаа зээлдсэн үг нь ямагт сунжирч бүр танигдах аргагүй болсон ч явдал байдаг юм. Иймээс бүдүүлэг аймгийнхан Хятадад ирж суурьшаад төрөлх хэлээ бусад соёлын өвтэйгээ хамт гээдэг тухай дүгнэлт хийхэд хялбархан болно. Гэтэл Төв Ази, Ойрхи Дорнодод иран, турк-монгол (Ираи, Туран) хоёр гол том хэлний групп байдаг боловч тэдгээрийн хоорондох зааг нь тийм ч эрс тэс биш байжээ. Юу гэвэл энд хот, тосгон, түүний ойролцоох малчид зэрэг хүн ам нийтдээ нэг ижил хэлээр буюу түүний төрлийн нутгийн аялгуугаар ярилцдаг байна.

Гэвч эдгээр онцлог нь нэг талаас Хятад ба нөгөө талаас Төв Ази, Ойрхи Дорнодын соёлын харилцаа хаалттай байсан гэдэг үг биш юм. Үүний баримт нь Хятадад (Шан улс) манай эриний өмнөх хоёр мянган жилийн тэртээ цэрэг дайнд хэрэглэж байсан хоёр дугуйтай тэрэг нь хэдийгээр Хятадаас Ойрхи Дорнод, умард Энэтхэг тэр ч байтугай Европын тал нутаг хүртэл тархсан түүхтэй ч гэсэн уг гарал нь яавч Хятадаас биш, харин Ойрхи Дорнод буюу Төв Ази бөгөөд гагцхүү тэндээс Хятадад нэвтэрсэн байх ёстой билээ. Түүнчлэн бүддийн шашин бас л Төв Азиар дамжиж Хятадын Хан улсад нэвтэрчээ.

Хятад, Монгол, Төв ба Дундад Ази

Хятадын ноёрхол буурч тэд Их хэрмээсээ дотогш эгэж буцсан цагт ардаа юу үлдээсэн, эсгүүл бүдүүлэг аймгийнхан Хятадад түрэгдэж эх нутаг тийшээ ухрахдаа Хятадаас юутай буцсан бэ? гэдэг асуудлыг сонирхууштай. Энэ талаар бид хятадын нээлт, техник сэлт бусад орнуудад дэлгэрсэн тухай хэзээнээс нааш тэмдэглэсээр ирсэн билээ. Тийнхүү Хятадаас үүсч дэлгэрсэн зүйл олон бөгөөд харин тэдгээр нь их төлөв Төв Ази, Ойрхи Дорнодоор дамжиж аль алс зайдуу нутаг орон тусам улам хүчтэй нөлөөлж байжээ. Тухайлбал, Ойрхи Дорнод ба Төв Азийн улс оронд гарсан өөрчлөлт, ард түмний нь аж төрөх ёс, оюун санаанд нь нөлөөлсөн нөлөө юу байгаа, түүний учир шалтгаан юу болохыг нарийвчлан үзэх нь зүйтэй билээ.

Үүнд, Хүмүүсийн үзэл суртлыг буй болгогч аж амьдралын нөхцлийг эхлэн үзэх ёстой боловч тухайн асуудлаар юуны өмнө үзэл суртлаас эхлэх нь зохимжтой юм. Газар зүйн ойролцоо нөхцөлдөөн, олон зуун жилийн турш нааш цааш явалцаж хэлхээ холбоотой байсан Ойрхи Дорнод ба Төв Азийн орнуудын ард түмэн тэд янз бүрийн шашин, үзэл санаа-

ны системийг үзэж өнгөрөөсөөр ирсэн зэргээс үзэхэд Хятадад дэлгэрсэн күнзийн ёс дээрх орнуудад нэгэн адил дэлгэрч болохсон билээ. Гэтэл күнзийн сургаалын нөлөө дээрх орнуудад огт газар авсангүй ажээ. Энэ бол күнзийн сургаал нь уламжлалт хятадын нийгмийн үндсэн илэрхийлэл болж түүнийг бусад нийгмийн нөхцөлтэй зэрэгцүүлэн тавьж болохгүйг харуулж байна. Тийнхүү уг асуудлын гол гогцоо, тухайлбал күнзийн ёс хятадаас бусад орон дэлхийд түгэж амжаагүйн учир шалтгааныг хаанаас эрэх ёстой вэ?

Күнзийн сургаалыг ялангуяа марксистууд феодалын сургаал гэх нь олонтой байдаг боловч миний бодоход энэ асуудал тун маргаантай асуудал юм. Ямар ч атугай Күнзийн сургаал бол хэрэг дээрээ түүхийнхээ бүхий л үеийн туршид иргэний эрхийг цэргийн эрхтний дээгүүр тавьдаг байв. Гэтэл нүүдэлчин аймгууд феодалын нийгмийн түрүү, сүүлч аль ч үед удирдагчдынхаа цэргийн эрх дарх, түүнд үнэнч байх ёсыг хэзээ ямагт дээгүүр тавьсаар иржээ. Ийм нэгэн онцлогийг анхаарах нь зүйтэй бөгөөд нөгөө талаар худалдаачдын эрх мэдлийн ялгааг бас зөв ухах нь чухал юм. Күнзийн системийн үед худалдаачид нь газрын эздээс түрээс төлбөр, өглөг зэрэг хэлбэрээр хуримталсан бүтээгдэхүүнийг зөвхөн хуваарилах, борлуулах л үүрэгтэй байв. Газрын эзэд нь улс төр, засаг захиргааны хувьд зонхилгогч эрхээ хамгаалахын тулд худалдаачдаас татвар хураах зэрэг аргаар тэдний хүч хөрөнгийг хязгаарлаж улс төрийн талаар тусгаар эрхтэй болохоос нь аль болохоор зайлуулж байв. (Хятадын өнөөгийн түүхчдийн томъёолж байгаа «капитализмын үр хүврэл»-ийн үеийн онцлог нь худалдааг өргөтгөх талаар Их хэрмийн гаднаас эрэлт шаардлага нэмэгдсэнтэй холбогдож худалдаачдын чадал мэдэл түр зуур дээшлэсэн үе гэж би газар сайгүй бичсэн билээ).

Их хэрмийн гадна этгээдэд байдал өөр бөгөөд энд худалдаачид нилээд дээгүүр эрх мэдэлтэй байв. Нүүдэлч малчдын нутгийг дайрч гардаг маймаачин жинчид нүүдэлчин аймгийн удирдагчдын эрх мэдлийг хөнддөггүй байжээ. (Манж-Хятадын захиргаанд оршиж байсан 18—19-р зууны үеийн Монгол дахь хятадын мөнгө хүүлэгч худалдаачдын цус соргогч үйл ажиллагаа нь дээр дурдсан зүйлд үл хамаарна). Төв Азийн баян бүрдүүд ба Дундад Дорнодын худалдааны хотуудад хотын захиргааны байгууллагууд байсан бөгөөд худалдаачид нь тэдэнтэй сүлбээтэй болж улмаар улс төрийн бодлогод нь нөлөө үзүүлдэг байжээ. Эцсийн эцэст нийгмийн системүүдийг бид феодал буюу ямар нэгэн өөрөөр нэрлэсэн ч Хятадын их хэрмийн гаднах нутаг дэлхий нь оюун санааны хувьд тухайлбал, нийгмийн үзэл санаа, техникийн талаар ч гэсэн Хятадаас мэдэгдэхүйц тусгаар тогтносон байдалтай байжээ. Тэдгээр нутаг орон нь Хятадын бордоотой бордоогүй зөвхөн оршин тогтнох төдийгүй, харин цэцэглэн хөгжих чадалтай байлаа. Тэр ч байтугай нөлөө бүхий шинэ үзэл санаа нэвтэртэл, тэр нь гол төлөв Хятадаас биш, харин Энэтхэг болон Ойрхи Дорнодоос ирж байжээ. Шинээр нэмэх зүйл нь зөвхөн нэг дээр нөгөөг давхарлан тавих гэсэн хэрэг биш юм. Дундад Дорнод ба Төв Азид гаднаас орж ирсэн алив зүйлс нь шингэж, шилжиж, амьдран орших төрх төлөвөө олсон байдаг.

Одоо, Ирээдүй: Капитализм ба Социализм

Сибирь ба Дундад Дорнодод их Оросын нөлөө нэвтэрч эхлэсэн явдал ч дээрхийн нэгэн ижил үзэгдэл юм. 1500-гаад оны сүүлчээр Монголд Оросууд ойртож байхад Манж нар Хятадыг байлдан дагуулахаар хүч хуралдуулж байв. 1800-гаад оны сүүлчээр буюу 300 жилийн дараа оросууд хүчтэй болж Сибирь нутаг ба одоогийн Төв Азийн Зөвлөлт бүгд

найрамдах улсуудын нутаг дэвсгэрт хүртэл бэхжээд байхад Манжийн эзэн хаант улс бүр ялзран унах байдалд ороод байжээ. Дээрх 300 жилийн хугацаанд Хаант Орос нь амжилтат империалист түүхийнхээ хуудсыг бүлэг бүлгээр нь ахиулан бичихийн сацуугаар нийгэм, эдийн засгийнхаа хөгжилтөд шилжилт явуулж түргэн хөгжсөөр бүхий шинэ залуу капиталист улс болжээ. Энд өгүүлэн буй сэдэвтэйгээ холбож үзэхэд тухайн үедээ орос ба орос бус үндэстэн ястан нь олон талаар харилцан бие биедээ нөлөөлж байсан нь сонирхолтой. 19-р зууны эцсээр нэгэн орос хүний бичсэнээс үзэхэд оросуудаас буриадад авчирч өгсөн юм нь төмөр анжис байжээ. Түүнийг нь буриад нар оросоос илүү сурамгай эзэмшин ашиглажээ. Түүнчлэн хожим Америкаас хөдөө аж ахуйн машин техник худалдан авч хэрэглэх үед аанай л буриадын шинэ хөрөнгөтөн ангийн гаралтай жижиг үйлдвэрийн эзэд Америкийн ганзага (агент) болж тэдгээр машиныг оросуудад худалдан борлуулж байв. Энэхүү жижиг өгүүлэлд тэр болгоныг багтаах аргагүй бөгөөд гагцхүү оросын империализм нь ард түмний хэлхээ холбоог туйлын өргөтгөж, тэдний амьдралыг ойртуулж өгсөн эерэг талтайг тэмдэглүүштэй. Англи, Франц, Голланд зэрэг гүрнүүд далайн испериализмын үед ар талдаа ард түмнээ орхиж гагцхүү усан цэрэг, түшмэд, худалдаачид, хар лам нарыг ачиж гадаад далайд гардаг байв. Үүний нэг үр дагавар нь ноёлогчид ба ноёлогч ангийн гоц ялгаа болно. Өөрөөр хэлбэл дээрх орнуудын байлдан дагуулагчдын бүрэлдэхүүн нь гол төлөв ноёлогч ангиас бүрддэг ажээ. Гэтэл хуурай замд тулгуурласан Оросын байлдан дагуулалт нь ажилчин, тариачны нэвтрэлттэй хамт буюу бараг хамт явагджэ. Оросын ажилчин, тариачид нь хаа очсон газраа улаан гараараа ажиллаж, эмэгтэйчүүд нь ямар ч зарцгүйгээр үүрэгт ажлаа өөрснөө гүйцэтгэж байсан жишээтэй ажээ. Тийнхүү байлдан дагуулагчдын дотор ч тэдний нэгэн адил дээд, доод ангийн ялгаа оршиж байдгийг дагагчид нүдээр үзэж бас тэдний ноёлогч анги нь хоорондоо хуйвалдан сүлбэлдэх ба эрх мэдэлгүй дарлагдагчид ч гэсэн хэл, шашин шүтлэгийн ялгаа үл харгалзан нийтлэг хэргийн төлөө нийлж тэмцэх тийм хандлага буй болдог ажээ. Дорнод ба Өмнөд Сибирь, Төв Азийн Зөвлөлт бүгд найрамдах улсуудын орон нутгийн музейг үзэхэд зүгээр. Тийм музейнүүд хот бүрээр зогсохгүй тосгонд ч байх бөгөөд музейд Октябрийн хувьсгал орон нутагт хэрхэн ялсныг харуулсан булан буюу үзмэрийн зүйл заавал байдаг юм. Тэнд анхны зэвсэгт бослогод оролцсон эрэгтэйчүүд (зарим эмэгтэйчүүд)-ийн гэрэл зураг байх бөгөөд харин орон нутгийн орос бус ард түмэн буюу ард түмнүүд оросуудтай хамтраагүй тийм гэрэл зураг олж харахад хялбаргүй. Большевик хувьсгал зөвхөн зонхилогч орос ард түмнээр хязгаарлагдсангүй Хаант Оросын нийт ард түмний дунд үүсч гарсныг харуулах бодит баримт үүнээс өөр юу байх билээ. Үүний зэрэгцээгээр цөөн тоот ард түмний дээд ангиас Оросын ноёлогч ангитай ойр дотно сүлбэлдсэн тэдгээр хүмүүс нь хувьсгалын эсэргүү нар буюу эсгүүл салан тусгаарлах үзэлтнүүд болжээ. Тийнхүү хувьсгал нь нийгмийн янз бүрийн давхаргын орос ба цөөн тоот ард түмнийг нийтэд нь хамарсан нарийн төвөгтэй ангийн дайн байв.

Монгол орон шилжилтийн үед орсон байв. Энд хятадын эдийн засгийн үйл ажиллагаа нь монгол ноёд ба сүм хийдтэй «түнш» болсон мөнгө хүүлэгч худалдаачдын онц эрхэд шилжсэн ба монгол «түнш» нь хятад худалдаачид өр авлагаа цуглуулахад нь тусалдаг байжээ. Түүний зэрэгцээгээр мөн орос худалдаачид байсан ба тэд нар нь «тэгш бус» империалист гэрээнүүдийг өөрсдийн эрх ашигт самбаачлан ашиглаж байв. Харин жижиг худалдаачид нь монголчуудтай ах дүү болохдоо хятадаас илүү бөгөөд монголоор сайн ярих орос хүн захаас аван байхад монгол эхнэр

авч хүүхэд гаргатлаа 20—30 жил тус оронд суусан маймаачин хятад монголчуудтай дөнгөн данган модон хэлээр нэвтрэлцдэг жишээтэй.

Тэнд мөн орос, монгол аль алианаар нь ярьдаг цэргийн орос дарга нар ба буриадууд монгол цэрэг дарга нарт пулемёт, их буу зэрэг орчин үеийн зэвсэг заадаг цэргийн сургууль хичээллэнэ. Дарга нарын зарим нь ширүүн догшин боловч зарим хагас нь сургаж байгаа монголчуудынхаа хайр талархлыг хүлээж ах дүү болно. Цэргийн сургуульд газар бүрээс татан оролцуулах учир тиймэрхүү сайн санаат орос хүмүүсийн дуулиан төдөлгүй орон даяар тархжээ. Тэдгээрээс гадна Урга (хожим Улаанбаатар) хотод хэдэн мянган хүнтэй орос хороолол байсан ба оршин суугчдын тоо нь 1971 оноос хойш Сибириэс дүрвэж ирэгсдээр улам нэмэгдэв. Энэ хороолол нь хаант засгийн бяцхан загвар бөгөөд тэндээс хааныг бишрэн дэмжигчид, сүүл хирд Колчакийг дэмжигчид, барон Унгерны талынхан, бас коммунист намын нууц гишүүд, аль алианаас нь тусгай улс төрийн элдэв урсгалын төлөөлөгч зэрэг төрөл бүрийн хүмүүсийг олж болно. Тэд хоорондоо зөрчил тэмцэлтэй байсан ба монголчуудын дотроос тусалж дэмжих хүмүүс хайна. Энэ мэтээр монголчуудын хувьд нэг ёсны улс төрийн шуурхай сургууль болж байв.

Энэхүү товч тойм төдийд ч гэсэн Октябрийн хувьсгалын цууриагаар болж байсан үйл явдлыг тайлбарлахын тул нилээд олон зүйлийг дурдлаа. Хятадуудын олонхи нь буцсан ба эдийн засгийн хувьд монголын шинэ хөрөнгөтнүүд нь нийгмийн өөр давхарга болсон учир ихэнх нь малчин ард болох эгэл жирийн монголчууд цөөн тооны гар үйлдвэрийнхний хамт угсаа залгамжлагч феодал ноёд, шашныг толгойлогч том лам нартай халз мөргөлдөн тунаж үлджээ. Тэр хоёрын хооронд ямар нэгэн дунд анги байсангүй.

Монголын хувьсгалын дүр төлөвийг бүрэлдүүлсэн гол хүчин зүйлс эдгээр болно. Монгол улс хөрөнгөтний хувьсгалын шатыг нэгэнт алгасч улмаар ЗХУ-ын туулж өнгөрөөсөн түүхэн үе шатуудыг дэс дараалан давтав. ЗХУ-ыг дууриах нь мэдээжийн хэрэг бөгөөд тэгж буй нь ч үнэн билээ. Харин хятадын зүгээс туссан хувьсгалт үзэл санаа, арга туршлагын талаар тийм зүйл огт байгаагүй мэтээр чимээгүй өнгөрдөг тал бий. Гэвч энэ бол хэргийн гол нь биш. Гол асуудал тэдгээр зүйлүүд Хятадад яагаад үгүй байв? гэдэгт оршино.

Уг асуудалд өгөх хариултын хагасыг Төв Ази ба Дундад Дорнодын түүхнээс эрүүштэй бөгөөд эл өгүүлэлд тэр талаар мэр сэр зүйлийг цухас төдий хөндлөө. Тэр түүхийн бүтээсэн даавуу материалын зарим утсыг дахин ээрч капитализмын шинэ даавуу нэхэж болох байсан бөгөөд гэтэл дүгнэн үзвэл дахин ээрч социализмын шинэ даавууг амжилт-тайгаар үйлдвэрлэж байна. Тэдгээр утас нь хүй нэгдлийн бүтэц, хамтын ажиллагааны махбодыг агуулсан байдаг юм. Монгол ба Төв Ази, Дундад Дорнодын Зөвлөлт бүгд найрамдах улсуудын түүх бол биеэ даасан судалгаанд бүрэн хүрэлцээтэй баялаг уудам талбар юм. Хэдий тийм боловч энэ талбарын үүд хаалга нь Хятад, Энэтхэг, Ойрхи Дорнод, Оросын нөлөөнд хэзээ ямагт нээлттэй байна. Энэ нь нөгөө талаар урт удаан хугацааны турш (бараг 60 жил) орос бус ард түмний дунд улс төр, эдийн засаг, соёлын хувьсгалыг марксист зарчмын дагуу ухамсартайгаар мандуулан хөгжүүлсэн район юм. Тэдгээрийн түүхэнд алдаа завхрал, осол гэмшлийн зэрэгцээгээр шинэ үзэл санаанд сайн дураар шилжих гялалзсан сайхан амжилт, эрхэм чухал үлгэр жишээ нэгэн адил дүүрэн байгааг түүхэн туршлага нотолж байна.

Шинэ маягийн түүхэнд шилжих энэ бүх хөдөлгөөн дэлхийн II дайнаас өмнө анхныхаа гарааг эхэлсэн юм. Тэр дайнаас хойш үйлдвэржи-

хийн өмнөх үеийн улс нийгэмүүдийн эдийн засгийн хөгжилт тэдгээрийн нийгэм, соёлын дагавар асуудлуудын хамт дэлхий дахины ач холбогдолтой чухал асуудал болжээ. Капиталист ба чинээлэг орнууд мөн марксист маягийн байгуулалттай ЗХУ болон Хятад эдгээрийн аль алинд нь улс орноо хөгжүүлэх ажил зохиогдож байна. Иймээс тэдгээрийг хооронд нь харьцуулан судлах явдал улам бүр чухал ач холбогдолтой бөгөөд тийнхүү харьцуулалт хийхдээ бид зөвхөн тусламж амлаж байгаа улс орнуудын зарчим дэглэмийг төдийгүй, бас тусламж авагч улс орны түүх, соёлын шинж чанарыг судлах явдал хойшлуулшгүй чухал шаардлагатай билээ.

Англи хэлнээс **Э. Пунцаг** орчуулав.